МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 04 өдөр Дугаар А/121 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх журам"-ыг хавсралтаар батлсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/-д тус тус даалгасугай.

3. Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг холбогдох байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Журам батлагдсантай холбогдуулан "Журам батлах тухай" Хөдөлмөрийн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/174, "Аргачлал батлах тухай" Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/21 дүгээр тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Н.НОМТОЙБАЯР

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2017 оны 07 дугаар сарын 04-ны
өдрийн А/121 дугаар тушаалын хавсралт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг зохион байгуулж буй байдал, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үйлчилгээний цар хүрээ, хүртээмж, ажлын үр дүн, байгууллагын үйл ажиллагаанд гарч буй ахиц дэвшил, алдаа, сургамжийг тодорхойлж цаашид үйл ажиллагааг сайжруулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах, шагнаж урамшуулахад энэхүү журмыг баримтлана.

Хоёр. Хамрах хүрээ

2.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний дараах байгууллагууд /цаашид харьяа агентлаг, байгууллага гэх/ хамрагдана.

Үүнд:

2.1.1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг:
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар,
- Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар,
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;

2.1.2. Яамны харьяа байгууллага:
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв,
- Хөдөлмөр, нмйгмийн хамгааллын судалгааны институт,
- БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв.

2.1.3. Харьяа байгууллага:
- Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний тєв,
- Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор,
- Өнөр бүл хүүхдийн төв,
- Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв,
- Ахмад настны үндэсний төв,
- Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв,
- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд,
- Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрууд.

2.2. Яамны хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгж харьяа агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд, агентлагийн хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгж харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ.

2.3. Яамны хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгж Төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг дарга нартай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний хэрэгжилтэд хяналт тавин ажиллах бөгөөд жилд 2-оос доошгүй аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт, харьяа газар, хэлтсүүдийн үйл ажиллагаанд газар дээр нь очиж хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ.

2.4. Шаардлагатай тохиолдолд яам болон харьяа агентлагийн хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгж харьяа байгууллага, газар, хэлтсүүдийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ.

2.5. Төсөв захирагчаас холбогдох байгууллагуудтай байгуулсан "Төрийн зарим чиг үүргийг Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээ"-ний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгж хяналт тавина.

2.6. Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн өөрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийн хагас, бүтэн жилээр агентлагийн Хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжид ирүүлнэ.

2.7. Харьяа агентлаг, байгууллага нь өөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжээр үйл ажиллагааны гүйцэтгэлд үнэлгээ хийлгэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан, мэдээллийг дүгнэлт, зөвлөмжийн хамт хагас, бүтэн жилээр яамны хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжид хэвлэмэл болон цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.8. Яамны хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгж нь харьяа агентлаг, байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл болон төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээг хагас, бүтэн жилээр үнэлэн үнэлгээний нэгдсэн дүнг Сайдын зөвлөлд танилцуулна.

2.9. Тайлант жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд дараах үнэлгээг харгалзан үзэж, тухайн байгууллагын ерөнхий үнэлгээний дүнг нэгтгэн гаргана. Үүнд:

2.9.1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ;
2.9.2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ;
2.9.3. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ;

2.10. Журмын 2.9, 3.1-т заасан тайлангийн загвар болон үнэлгээнд хамаарах шалгуур үзүүлэлтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар яамны холбогдох газар, хэлтэстэй хамтран тухайн байгууллагын үндсэн чиг үүрэг, салбарын бодлогын зорилт, үйл ажиллагааны онцлогийг харгалзан боловсруулна.

2.11. Харьяа байгууллагуудын үр дүнг үнэлэх үзүүлэлтийг энэхүү журмын Нэгдүгээр хавсралтын дагуу, байгууллагын эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтын дагуу, холбогдох тайлан, мэдээллийг 3-9 дүгээр хавсралтын дагуу тус тус гаргана.

Гурав. Тайлагналт

3.1 Тайлант жилийн үйл ажиллагаандаа хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлсэн тайланг харьяа байгууллагууд батлагдсан загварын дагуу гаргаж харьяалах дээд шатны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжид ирүүлнэ.

3.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хариуцсан нэгж харьяа байгууллагуудаас ирүүлсэн тайлан, мэдээлэлд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг ТЕЗ, ТТЗ-д танилцуулна.

3.3 Журмын 2.1-т заасан байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж, ажилтан холбогдох асуудал хариуцсан газар, нэгж, ажилтнаас тайлан мэдээллийг нэгтгүүлэн авч уг журмын дагуу хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

3.4 Журмын 3.1-т заасан үнэлгээний тайланг ирүүлэхдээ салбарын хүрээний бодлого, зорилго нь зорилтот түвшиндээ хүрсэн байдал болон тухайн байгууллагаас үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой тоогоор илэрхийлэх боломжгүй чанарын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийн, ахиц, бууралт, гарсан өөрчлөлтийн талаар дэлгэрэнгүй байдлаар тайланд оруулна. Үнэлгээний тайланд тогтоогдсон нөхцөл байдал, холбогдох тоо баримт, хүснэгт, график, санал, дүгнэлтийг тусгасан байхаас гадна шаардлагатай бол зураг, дүрс бичлэг зэргийг хавсаргах бөгөөд тайланд байгууллагын дарга, захирал гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Дөрөв. Үнэлгээ хийх арга зүй

4.1 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж хариуцан уг журам болон Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу үнэлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох газрууд болон хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр мэргэшсэн ажилтан болон судлаачдын төлөөллөөс бүрдүүлсэн багийг оролцуулж болно.

4.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгасан тоон болон тоогоор илэрхийлж болох үзүүлэлтийг албан ёсны болон захиргааны статистик мэдээ, тухайн үйл ажиллагааны хүрээний асуудлыг хариуцсан байгууллагын судалгааны үзүүлэлт, тухайн жилд яам болон бусад дээд шатны байгууллагаас газар дээр нь ажилласан ажлын хэсгийн тайлан, дүгнэлт зэрэгтэй харьцуулан нягтална.

4.3 Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ баримт бичиг судлах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг аргуудыг хэрэглэнэ.

4.1 Тухайн байгууллагын үйл ажиллагааны ерөнхий үнэлгээг үзүүлэлт бүрийн хэрэгжилтийн түвшин (хувь)-ийн нийлбэрийг нийт үзүүлэлтийн тоонд хуваах тооцно.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн төвлөрүүлэн захирагчтай, төсвийн төвлөрүүлэн захирагчаас төсвийн шууд захирагчтай тухайн онд байгуулсан гэрээний биелэлтийг гэрээг дүгнэсэн хувиар тодорхойлно.

4.3 Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн түвшинг тодорхойлохдоо тавьсан зорилтын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үр дүнг (Г) хүрэх түвшин буюу тавьсан зорилтод (3) харьцуулж хувиар илэрхийлнэ (Г/3х100).

4.4 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын тухайн жилийн үйл ажиллагааны үнэлгээний дүнг гаргахдаа үзүүлэлт бүрийн үнэлгээг 100 хүртэл хувиар илэрхийлэн нийлбэр үнэлгээний арифметик дунджийг харгалзах жинд шилжүүлнэ. Ерөнхий үнэлгээг тодорхойлохдоо жинд шилжүүлсэн дүнгүүдийн нийлбэрийг 0.05-аар үржүүлж, 0-5 хүртэл оноонд шилжүүлэн дүгнэнэ.

Е-ерөнхий үнэлгээ;
α-бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хувь;
β-байгууллагын чиг үүргийн биелэлтийн хувь;
γ-байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ;
n-бодлогын баримт бичгийн тоо;
m-байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн тоо;
k-байгууллагын нээлттэй байдлын үзүүлэлтийн тоо;
i–үзүүлэлтийн дугаар;

$$E=0.05*[(1/n \sum_{i=1}^{n}(\alpha_i))*0.6+(1/m \sum_{i=1}^{m}(\beta_i))*0.2+(1/k \sum_{i=1}^{k}(\gamma_i))*0.2]$$

Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх

5.1 Жилийн үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан 2 байгууллагыг шалгаруулан дараах байдлаар шагнаж урамшуулж болно.

- 1 дүгээр байр 5.000.000 төгрөг.
- 2 дугаар байр 3.000.000 төгрөг.

5.2 Урамшуулалд зарцуулах хөрөнгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын хөрөнгөнөөс санхүүжүүлнэ.

5.3 Захиргааны байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан зөвлөмж, дүгнэлтийн дагуу холбогдох арга хэмжээг авч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.3.1 Яам, харьяа байгууллагуудын тэргүүний арга, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, гарсан алдаа, дутагдлыг засах;

5.3.2 Захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

5.3.3 Харьяалах захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар үүрэг, чиглэл өгөх, шаардлагатай тохиолдолд зохих удирдамжийн дагуу газар дээр нь хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах;

5.3.4 Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн тухайн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцан зохион байгуулна.

Зургаа. Хариуцлага

6.1 Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний дүнгээр хоёр удаа хангалтгүй үнэлгээ авсан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт нь буурсан харьяа агентлаг, байгууллагуудын даргыг Төрийн албаны тухай хуулийн 23.1-д заасны дагуу албан тушаал бууруулах саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжлах.

6.2 Тайлант жилийн үр дүн, гүйцэтгэлийг үнэлж, дүгнэсний үндсэн дээр нийт үнэлгээний дүнгээр 60-аас доош хувьтай үнэлэгдсэн, өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй, худал, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан зэрэг зөрчил гаргасан албан тушаалтанд Төрийн албаны тухай, Төсвийн тухай болон холбогдох бусад хуульд зааснаар хариуцлага хүлээлгэнэ:

---o0o---

Журмын 1 дүгээр хавсралт.

БАЙГУУЛЛАГЫН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

(.... оны үйл ажиллагааны үр дүн)

№	Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт		0.6	
		2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт			
		3.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт			
		4.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ			
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Тушаал, шийдвэрийн хэрэгжилт		0.2	
		2.Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт			
		3.Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт			
		4.Дотоод аудитын хорооны тогтоол, албан даалгавар болон хөндлөнгийн байгууллагын хяналт, шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт			
3	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ		0.2	
		2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ			
Ерөнхий үнэлгээ				**1.0**	

---o0o---

Журмын 2 дугаар хавсралт

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт		Зорилтод түвшин Тайлант он	Хүрсэн түвшин	Хувь	Оноо
Нэг. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар						
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан хүний тоо (хуулийн хүрээнд)					
2	Шинээр бий болсон ажлын байрны тоо	Нийт				
		Үүнээс: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хүрээнд				
3	Ажил хайгч, ажил олгогчийг шууд холбох хөдөлмөр зуучлалын мэдээллийн биет болон онлайн сүлжээг нэвтрүүлэх					
4	Нийт бүртгэгдсэн ажилгүй иргэдийн тоонд ажилд зуучлагдан орсон хүний эзлэх хувь					
5	Нийтлэг үйлчилгээнд хамрагдсан хүний тоо:					
	- Нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо					
	- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгож зөвлөгөө өгч мэдээллээр хангасан иргэний тоо					
	- Ажилд зуучилсан иргэний тоо					
6	МБСБ-д элсэгчдийн тоо					
7	МБСБ төгсөгчдөөс ажлын байртай болсон хувь					
8	Нэг ядуу өрхөд зарцуулах нийгмийн халамжийн зардал					
9	Ядуу өрхөд чиглэсэн үйлчилгээний нэр төрөл					
10	Сэргээн засах үйлчилгээ авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо					
11	Протез ортопедийн хэрэгсэл хийлгэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо					
12	Мэргэжлийн ур чадвар олгох сургуульд хамрагдсан хүүхдийн тоо					
13	Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо					

14	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, үүнээс байнгын ажлын байраар хангагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо				
15	Халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн тоо				
16	Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн тоо				
17	Халамжийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо /зардлын дүн, үйлчилгээний төрлөөр/				
18	Байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан хүүхдийн тоо				
19	Байнгын асаргаа шаардлагатай хүүхдээ асарч буй асаргааны дэмжлэгт хамрагдсан хүний тоог а) өвчний шалгаанаар, б) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа гэсэн ялгаатай хэмжигдэхүүнээр гаргах				
20	Халамжийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, шалтгааны ангиллаар				
21	Өрхийн амьжиргааны түвшний босго онооноос доош оноотой өрхөд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо				
22	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эхэд зориулсан тогтмол болон цагийн ажлын байрны тоо, хамрагдсан хүний тоо				
23	Хүйсээр ангилан гаргасан захиргааны статистик /бүртгэл, судалгаа/-ийн тоо, нийт захиргааны статистикт эзлэх хувь				
24	Тус байгууллагын хүний нөөцийн байдал нь хүйсийн тэнцвэрт байдлыг хангасан байдал, ЖЭТБХтХуульд заасан квоттой харьцуулах				
Хоёр. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв					
1	Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийгдсэн ажлын байрны тоо				
2	Мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүний тоо				
3	Хөдөлмөрийн нөхцөл, МШӨ-өөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын тоо				
4	Нийт ажиллагагсдын тоонд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчлөгсдийн тооны эзлэх хувь				
5	Үйлдвэрлэлийн ослын тоо				
6	Мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчлөгсдийн тоо				

7	ХАБЭА-н урьдчилан сэргийлэх сургалтад хамрагдсан хүний тоо, хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо					
8	Нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо					
9	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай болон мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар хийсэн сургалт, арга хэмжээний тоо					
10	Ажил, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болж буй иргэдийн тоо					
11	Хүйсээр ангилан гаргасан захиргааны статистик /бүртгэл, судалгаа/-ийн тоо, нийт захиргааны статистикт эзлэх хувь					
12	Тус байгууллагын хүний нөөцийн байдал нь хүйсийн тэнцвэрт байдлыг хангасан байдал, ЖЭТБХтХуульд заасан квоттой харьцуулах					
Гурав. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар						
1	Нийгмийн даатгалд хамрагдалтын байдал	Ажил олгогч				
		Даатгуулагчийн тоо /хүн/				
		Сайн дурын даатгалд хамрагдалт /хүн/				
		Үүнээс: малчин				
2	Шимтгэл төлсөн дундаж цалин					
3	НДС-ийн орлогын төлөвлөгөөний биелэлт					
4	НД-ын үйлчилгээ авсан хүний тоо					
5	Авлагын хэмжээ					
6	НДС-аас олгох тэтгэвэр тэтгэмжийн хуулийн дагуу ТДС, ҮОМШӨДС-аас тэтгэвэр авч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо					
7	Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын тоо					
8	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо					
9	Эрүүл мэндийн даатгалаар эмнэлэгийн үйлчилгээ авагчдын тоо /жилд/					
10	Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн болон протез, ортопед, туслах, хэрэгсэлд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, нийт зардал					
11	Хөнгөлөлттэй нөхцөлөөр амралт, сувиллын газарт үйлчлүүлсэн ахмадын тоо					

12	Хүйсээр ангилан гаргасан захиргааны статистик /бүртгэл, судалгаа/-ийн тоо, нийт захиргааны статистикт эзлэх хувь				
13	Тус байгууллагын хүний нөөцийн байдал нь хүйсийн тэнцвэрт байдлыг хангасан байдал, ЖЭТБХтХуульд заасан квоттой харьцуулах				
***Дөрөв*. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар**					
1	Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн тоо				
2	Хүн амын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн хүний тоо /мян/				
3	Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо				
4	Гэр бүлийн хөгжилд чиглэсэн хөтөлбөр, төслийн тоо /төсөв, зарцуулалт, тайлан/				
5	Залуучуудын хөгжилд чиглэн хэрэгжүүлсэн хөтөлбөр, төслийн тоо /төсөв, зарцуулалт, тайлан/				
6	Хараа, хяналтгүй хүүхдүүдэд чиглэн хэрэгжүүлсэн хөтөлбөр, төслийн тоо/төсөв, зарцуулалт, тайлан/				
7	Ажил хөдөлмөр эрхэлж буй болон их дээд сургууль төгсөж буй залуучуудын тооны харьцаа				
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар 108 дуудлагын утсанд ирсэн мэдээллийн тоо, хариу арга хэмжээ авсан тухай тоо				
9	Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо				
10	Аймаг, дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төвөөр үзүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан үйлчилгээний төрөл				
11	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллагсад, нийгмийн ажилтнуудыг хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр сургалтад хамруулсан байдал, сургалтанд хамрагдсан албан хаагчдын тоо				
12	Гэр бүлийн хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааны үзүүлэлт /төвийн тоо, аймаг, хот, төсөв, төвийн ажилтны тоо, үйлчлүүлсэн хүний тоо, нас, хүйсээр/				
13	Ахмадын хөгжлийн төвийн үйл ажиллагааны үзүүлэлт /төвийн тоо, аймаг, хот, төсөв, төвийн ажилтны тоо,				

14	Түр хамгаалах байрны үйл ажиллагааны үзүүлэлт /байрны тоо, аймаг, хот, төсөв, төвийн ажилтны тоо, үйлчлүүлсэн хүний тоо, нас, хүйсээр/				
15	Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны үзүүлэлт /төвийн тоо, аймаг, хот, төсөв, төвийн ажилтны тоо, үйлчлүүлсэн хүний тоо, нас, хүйсээр/				
16	Хүүхдийн эрхийн зөрчлийн талаарх хандалт, тоо, хариу арга хэмжээ авсан байдлын тухай тоо мэдээ				
17	Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн тоо, эзлэх хувь				
18	Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо, эзлэх хувь				
19	Хүүхдээс хүлээн авсан өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн тоо, эзлэх хувь				
20	Хүүхдийн хөгжлийн төв, зуслангаар үйлчлүүлсэн хүүхдийн тоо, эзлэх хувь				
21	Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан ажилтны тоо				
22	Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн чиглэлээр сургалтанд хамрагдсан эцэг, эхчүүдийн тоо				
23	Хувь хүний хөгжлийг дэмжсэн амьдрах ухааны чадвар эзэмших сургалтад хамрагдаж, ойлголт хандлага сайжирсан залуучуудын тоо				
24	Цагийн ажилд зуучлагдсан залуучуудын тоо, үүнээс байнгын ажлын байртай болсон залуучуудын тоо				
25	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан залуучуудын тоо				
26	Цэргийн алба хаасан болон цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан залуучуудын тоо				
27	Сайн дурын ажилд хамрагдсан залуучуудын тоо, нийт цаг				
28	Хүйсээр ангилан гаргасан захиргааны статистик /бүртгэл, судалгаа/-ийн тоо, нийт захиргааны статистикт эзлэх хувь				
29	Тус байгууллагын хүний нөөцийн байдал нь хүйсийн тэнцвэрт байдлыг хангасан байдал, ЖЭТБХтХуульд заасан квоттой харьцуулах				
Тав. Хөдөлмөр, нмйгмийн хамгааллын судалгааны институт					
1	Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо				

14	Түр хамгаалах байрны үйл ажиллагааны үзүүлэлт /байрны тоо, аймаг, хот, төсөв, төвийн ажилтны тоо, үйлчлүүлсэн хүний тоо, нас, хүйсээр/				
15	Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны үзүүлэлт /төвийн тоо, аймаг, хот, төсөв, төвийн ажилтны тоо, үйлчлүүлсэн хүний тоо, нас, хүйсээр/				
16	Хүүхдийн эрхийн зөрчлийн талаарх хандалт, тоо, хариу арга хэмжээ авсан байдлын тухай тоо мэдээ				
17	Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн тоо, эзлэх хувь				
18	Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо, эзлэх хувь				
19	Хүүхдээс хүлээн авсан өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн тоо, эзлэх хувь				
20	Хүүхдийн хөгжлийн төв, зуслангаар үйлчлүүлсэн хүүхдийн тоо, эзлэх хувь				
21	Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан ажилтны тоо				
22	Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн чиглэлээр сургалтанд хамрагдсан эцэг, эхчүүдийн тоо				
23	Хувь хүний хөгжлийг дэмжсэн амьдрах ухааны чадвар эзэмших сургалтад хамрагдаж, ойлголт хандлага сайжирсан залуучуудын тоо				
24	Цагийн ажилд зуучлагдсан залуучуудын тоо, үүнээс байнгын ажлын байртай болсон залуучуудын тоо				
25	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан залуучуудын тоо				
26	Цэргийн алба хаасан болон цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан залуучуудын тоо				
27	Сайн дурын ажилд хамрагдсан залуучуудын тоо, нийт цаг				
28	Хүйсээр ангилан гаргасан захиргааны статистик /бүртгэл, судалгаа/-ийн тоо, нийт захиргааны статистикт эзлэх хувь				
29	Тус байгууллагын хүний нөөцийн байдал нь хүйсийн тэнцвэрт байдлыг хангасан байдал, ЖЭТБХтХуульд заасан квоттой харьцуулах				
Тав. Хөдөлмөр, нмйгмийн хамгааллын судалгааны институт					
1	Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо				

2	Хүүхэд, өсвөр үе, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гэр бүл, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээрх суурь судалгаа, эрдэм шинжилгээний ажлын тоо, тайлан				
3	Судалгааны үр дүнг холбогдох байгууллагад уламжилж, хамтран ажилласан талаарх тайлан				
4	Халамжийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөний явцад хийсэн судалгаа, дүн шинжилгээ				
5	Хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдийн асуудлаар гаргасан судалгааны товхимол, зөвлөмжийн тоо				
6	Хүйсээр ангилан гаргасан захиргааны статистик /бүртгэл, судалгаа/-ийн тоо, нийт захиргааны статистикт эзлэх хувь				
7	Тус байгууллагын хүний нөөцийн байдал нь хүйсийн тэнцвэрт байдлыг хангасан байдал, ЖЭТБХтХуульд заасан квоттой харьцуулах				

---o0o---

Журмын 3 дугаар хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

ЗГҮАХ-т тусгагдсан, зорилт	Арга хэмжээний дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)		Хэрэгжилтийн хувь
						Он		
						Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
1	2	3	4	5	6	7	8	9
ХӨГЖЛИЙН САЛБАР №1.1.								

Тайлан гаргасан: ..... мэргэжилтэн /...../

Хянасан: .....дарга /...../

Журмын 4 дүгээр хавсралт

УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр	Хүрсэн түвшин, хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1.							
1.1							
1.2							
1.3							

Тайлан гаргасан: ..... мэргэжилтэн /...../

Хянасан: .....дарга /...../

Журмын 5 дугаар хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
			Салбар чиглэл: 1		
1.а.Монгол Улсын хууль					
1.б.Улсын Их Хурлын тогтоол					
1.в.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол					
1.г.Ерөнхийлөгчийн зарлиг					
1.д.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл					
1.е.Засгийн газрын тогтоол					
1.ё.Ерөнхий сайдын захирамж					
1.ж.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
1.з.Засгийн газрын албан даалгавар					
Хэсгийн дундаж: ….. хувь					
			Салбар чиглэл: 2		
2.а.Монгол Улсын хууль...					
Хэсгийн дундаж: ….. хувь					
Нийт дундаж: ….. хувь					

Тайлан гаргасан: ..... мэргэжилтэн /...../

Хянасан: ..... дарга /...../

Журмын 6 дугаар хавсралт

ТУШААЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

№	Тушаалын нэр	Он,сар, өдөр	Дугаар	Хяналтад авсан заалтын дугаар	*Заалтын агуулга*	Биелүүлэх хугацаа	*Хэрэгжилтийн явц*	Үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9
Нэг. Сайдын тушаал								
1.								
2.								
Хоёр. Төрийн нарийн бичгийн даргын тушаал								
1.								
2.								
Гурав. Агентлагийн даргын тушаал								
1.								
2.								

Тайлан гаргасан: ..... мэргэжилтэн /...../

Хянасан: ..... дарга /...../

Журмын 7 дугаар хавсра.

ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

№	Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Зорилт, арга хэмжээний агуулга	Хэрэгжилтийн явц	Үр дүн	Үнэлгээ
1	2	3	4	5	6	7
Нэг. Үндэсний хэмжээнд баримтлах бодлого, хөтөлбөр, төсөл						
1.						
Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол						
1.						
Гурав. Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөлийн тогтоол						
1.						
Дөрөв. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол						
1.						
Тав. Бусад						
1.						

Тайлан гаргасан: ..... мэргэжилтэн /...../

Хянасан: ..... дарга /...../

Журмын 8 дугаар хавсралт

.....-НЫ ..... ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

(201.. оны жилийн эцсийн байдлаар)

№	Тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Биелэлт	Үнэлгээ
1.				

Тайлан гаргасан: ..... мэргэжилтэн /...../

Хянасан: ..... дарга /...../

Журмын 9 дүгээр хавсралт

ХӨНДЛӨНГИЙН БОЛОН ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, АУДИТЫН ЗӨВЛӨМЖ, САЙДЫН АЛБАН ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

20..... оны .....-р сарын .....өдөр

(201.. оны жилийн эцсийн байдлаар)

№	Хяналт, шалгалт, аудит хийгдсэн огноо, байгууллагын нэр	Өгөгдсөн зөвлөмж, үүрэг даалгавар	Хэрэгжүүлсэн байдал	
			Зохион байгуулсан ажил арга, хэмжээ	Гарсан үр дүн

Тайлан гаргасан: .... мэргэжилтэн /...../

Хянасан: .... дарга /...../

---o0o---